

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2023/04/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn	Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Саруул баян уул- Аудит” ХХК Захирал: Б.Шатар Утас: 99093852 Цахим хаяг: Shatar5626@gmail.com Аудитор: Д.Оюунбат Утас: 99973399 Цахим хаяг: Oyunbatdorjkhhand@gmail.com
Говьсүмбэр аймаг 2023 он	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govsumber@audit.gov.mn

2023.03.15 № 48
танай _____ -ны № _____ -т

ГОВЬСҮМБЭР "ИЛЧЛЭГ ШИВЭЭ"
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ш.ЧИНБОЛД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны "Илчлэг шивээ" ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн орлого, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн "Илчлэг шивээ" ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

000000178

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	77,131,428.13	134,417,457.03
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,738,394.01	22,340,644.52
3	Кассанд байгаа бэлэн мөнгө	333,672	
4	Төгрөг	333,672	
5	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,404,722.01	22,340,644.52
6	Төгрөг	8,404,722.01	22,340,644.52
7	Арилжааны банк дахь харилцах	8,404,722.01	22,340,644.52
8	АВЛАГА	35,364,206.32	68,330,770.95
9	Ажиллагчидтай холбогдсон авлага	584,648.78	
10	Бусад авлага	34,779,557.54	68,330,770.95
11	Байгууллагаас авах авлага	34,779,557.54	68,330,770.95
12	БАРАА МАТЕРИАЛ	33,028,827.8	43,746,041.56
13	Бэлэн бүтээгдэхүүн	911,217.72	
14	Хангамжийн материал	32,117,610.08	43,746,041.56
15	Бичиг хэргийн материал	406,436.52	578,018.29
16	Аж ахуйн материал	27,596,893.87	22,729,970.99
17	Сэлбэг хэрэгсэл	1,066,750	1,066,750
18	Түлш, шатах тослох материал	454,544.94	463,625.73
19	Бусад хангамжийн материал	2,592,984.75	18,907,676.55
20	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,764,157,598.07	1,659,771,325.71
21	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,764,157,598.07	1,659,771,325.71
22	Биет хөрөнгө	1,733,643,961.71	1,630,369,431.8
23	Барилга, байгууламж, орон сууц	195,739,889	195,739,889

Говьсүмбэр аймгийн “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

24	Хуримтлагдсан элэгдэл	-16,203,729.28	-21,495,004.72
25	Авто-тээврийн хэрэгсэл	2,000,000	2,000,000
26	Хуримтлагдсан элэгдэл		-666,666.72
27	Машин тоног төхөөрөмж(компьютер)	729,524,231	473,075,630.18
28	Хуримтлагдсан элэгдэл	-112,864,094.71	-101,982,924.43
29	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,473,831.81	40,045,231.81
30	Хуримтлагдсан элэгдэл	-24,581,597.84	-24,473,976.87
31	Бусад үндсэн хөрөнгө	1,049,629,271	1,270,061,762
32	Хуримтлагдсан элэгдэл	-147,073,839.27	-216,934,508.45
33	Дуусаагүй барилга, байгууламж	15,000,000	15,000,000
34	Биет бус хөрөнгө	30,513,636.36	29,401,893.91
35	Програм хангамж	8,163,636.36	6,863,636.36
36	Хуримтлагдсан элэгдэл	-1,800,000	-1,611,742.45
37	Бусад биет бус хөрөнгө	24,150,000	24,150,000
38	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,841,289,026.2	1,794,188,782.74
39	НИЙТ ӨР ТӨЛБӨР	831,218,871.68	844,818,639.27
40	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	211,763,871.68	88,028,149.27
41	Өглөг	211,763,871.68	88,028,149.27
42	Бусад өглөг	211,763,871.68	88,028,149.27
43	Байгууллагад төлөх өглөг	84,919,065.36	220,602.94
44	Татварын өглөг /ТӨҮГ/	46,943,350.01	87,387,603.17
45	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	79,901,456.31	419,943.16
46	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	619,455,000	756,790,490
47	Урт хугацаат зээл	619,455,000	756,790,490
48	Төгрөг	619,455,000	756,790,490
49	Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	619,455,000	756,790,490
50	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,010,070,154.52	949,370,143.47
51	Засгийн газрын хувь оролцоо	1,010,070,154.52	949,370,143.47
52	Засгийн газрын оруулсан капитал	2,337,169,892	2,337,169,892

Говьсүмбэр аймгийн “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

53	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,337,169,892	2,337,169,892
54	Хуримтлагдсан үр дүн	-2,085,997,602.73	-2,142,697,613.78
55	Өмнөх үеийн үр дүн	-1,909,218,495.12	-2,085,997,602.73
56	Тайлант үеийн үр дүн	-176,779,107.61	-56,700,011.05
57	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	758,897,865.25	754,897,865.25
58	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,841,289,026.2	1,794,188,782.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант огноо: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	52,708,436.71	687,275,784.04
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,708,436.71	687,275,784.04
3	Нийтлэг татварын бус орлого	52,708,436.71	687,275,784.04
4	Бусад орлого	6,000	358,751,274.53
5	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	549,982,536.59	777,019,245.81
6	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	497,280,099.88	448,494,736.3
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	148,391,575.05	743,975,795.09
8	УРСГАЛ ЗАРДАЛ	148,391,575.05	743,975,795.09
9	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	148,391,575.05	743,975,795.09
10	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	148,391,575.05	743,975,795.09
11	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	148,391,575.05	743,975,795.09
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-95,683,138.34	-56,700,011.05
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	81,095,969.27	
14	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	81,095,969.27	
15	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-176,779,107.61	-56,700,011.05

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,337,169,892	753,397,865.25	-1,909,218,495.12	1,181,349,262.13
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,337,169,892	753,397,865.25	-1,909,218,495.12	1,181,349,262.13
3	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		1,500,000		1,500,000
4	Өмчид гарсан өөрчлөлт		4,000,000		4,000,000
5	Тайлант үеийн үр дүн			-176,779,107.61	-176,779,107.61
6	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,337,169,892	758,897,865.25	-2,085,997,602.73	1,010,070,154.52
7	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,337,169,892	758,897,865.25	-2,085,997,602.73	1,010,070,154.52
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-4,000,000		-4,000,000
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,337,169,892	754,897,865.25	-2,085,997,602.73	1,006,070,154.52
10	Тайлант үеийн үр дүн			-56,700,011.05	-56,700,011.05
11	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,337,169,892	754,897,865.25	-2,142,697,613.78	949,370,143.47

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	497,586,655.29	877,075,555.35
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	497,586,655.29	877,075,555.35
3	Нийтлэг татварын бус орлого	497,586,655.29	877,075,555.35
4	Бусад орлого	6,000	18,019,284.96
5	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	497,536,722.29	859,056,270.39
6	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө /ТӨҮГ/	43,933	
7	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	474,025,637.61	863,473,304.84
8	УРСГАЛ ЗАРДАЛ	474,025,637.61	863,473,304.84
9	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	474,025,637.61	863,473,304.84
10	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	147,201,185	272,709,541
11	Үндсэн цалин	147,201,185	272,709,541
12	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,171,496.73	39,542,883.44
13	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	36,171,496.73	39,542,883.44
14	Хангамж, бараа материалын зардал	25,543,944.54	30,536,104.1
15	Бичиг хэрэг	438,554.54	3,893,363.64
16	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,036,930	1,105,467.73
17	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	290,000	250,000
18	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	22,778,460	25,287,272.73
19	Эд хогшил, урсгал засварын зардал	3,515,000	
20	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,515,000	
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	261,594,011.34	520,684,776.3
22	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	43,852,884.65	64,080,652.11
23	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	217,741,126.69	456,604,124.19

Говьсүмбэр аймгийн “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	23,561,017.68	13,602,250.51
25	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	15,636,180.81	
26	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,636,180.81	
27	Дотоод эх үүсвэрээр	15,636,180.81	
28	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	15,636,180.81	
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-15,636,180.81	
30	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	7,924,836.87	13,602,250.51
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	813,557.14	8,738,394.01
32	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,738,394.01	22,340,644.52

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 776.1 сая төгрөгийн 8 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Шатахууны урамшуулал 0.4 сая төгрөгийн орлого дутуу бүртгэсэн
- 4.0 сая төгрөгийн хөрөнгийг буруу бүртгэсэн
- Элэгдэлтэй шилжиж ирсэн 0.9 сая үндсэн хөрөнгийг үлдэгдэл үнээр бүртгэсэн
- Актлагдаад шинээр үнэ тогтоосон 7.0 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээний нэмэгдэл дансаар бүртгэсэн
- 434.3 сая төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийг дутуу бүртгэж, нийт ашиг /алдагдал/-ыг буруу тайлагнасан
- 319.2 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгийг илүү тайлагнасан
- ХХОАТ-ын өглөгийг илүү 5.8 сая төгрөгөөр илүү, НӨАТ-ын өглөгийг 1.7 сая төгрөгөөр дутуу, нийт 7.5 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан
- Санхүүгийн тайланд Цалингийн зардлыг 2.3 сая, НДШ-ийн зардлыг 0.4 сая төгрөгөөр тус тус илүү тайлагнасан

Аудитаар нийт 1,0 сая төгрөгийн 3 зөрчил² илэрсэн бөгөөд зөрчлийг арилгуулах 1 төлбөрийн акт, 2 зөвлөмж өгсөн байна.

5.1. Төлбөрийн акт

5.1.1. Ажилчдад ХХОАТ-ын хөнгөлөлтийг 0,6 сая төгрөгөөр илүү, 0.4 сая төгрөгөөр дутуу, нийт 1,0 сая төгрөгийн зөрүүтэй олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Татварын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.7, ХХОАТ-ын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

5.2. Албан шаардлага байхгүй

5.3. Зөвлөмж

1. Цалин хөлстэй холбоотой

1.1. Илрүүлэлт

Ажилчдад илүү цагийн хөлсийг хууль тогтоомж, заавар журмын дагуу олгоогүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 тушаалаар баталсан “дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын 2.2 дахь заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ажилчдын илүү цагийн хөлсийг хуулийн дагуу тооцож олгох

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Тус байгууллага нь 2017 онд батлагдсан НБББББ-т мөрдөхөөр заасан НББОУС-18, НББОУС-11, НББОУС-17 стандартууд хүчингүй болсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: НБББББ-ийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, заавар журамд нийцүүлэн дахин боловсруулах

Дээрх 2 зөвлөмжийн биелэлтийг “Саруул баян уул -Аудит” ХХК-д 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруула агүй		Тоо	Дүн
Шатахууны урамшуулал 0,4 сая төгрөгийн орлого дутуу бүртгэсэн	1	0.4	1	0.4			1	0.4				
Элэгдэлтэй шилжиж ирсэн үндсэн хөрөнгийг үлдэгдэл үнээр бүртгэсэн	1	0.9			1	0.9	1	0.9				
Актлагдаад шинээр үнэ тогтоосон хөрөнгийг дахин үнэлгээний нэмэгдэл дансаар бүртгэсэн	1	7.0			1	7.0	1	7.0				
Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг буруу бүртгэж, нийт ашиг /алдагдал/-ыг буруу тайлагнасан	1	434.3			1	434.3	1	434.3				
Хойшлогдсон татварын хөрөнгийг илүү тайлагнасан	1	319.2			1	319.2	1	319.2				
ХХОАТ-ын НӨАТ-ын өглөгийг илүү, дутуу тайлагнасан	1	7.5			1	7.5	1	7.5				
Цалин,НДШ-ийн зардлыг илүү тайлагнасан	1	2.7			1	2.7	1	2.7				
4.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг буруу бүртгэсэн	1	4.0			1	4.0	1	4.0				
дүн	8	776.1	1	0.4	7	775.7	8	776.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Говьсүмбэр аймгийн “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

ХХОАТ-ын хөнгөлөлтийг илүү, дутуу олгосон.	1	1.0	1	1.0								
Ажилчдад илүү цагийн хөлсийг хууль тогтоомж, заавар журмын дагуу олгоогүй	1						1					
НБББББ-ийн зарим стандарт хүчингүй болсон	1	0					1	0				
дүн	3	1.0	1	1.0			2	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд орлого зарлагын мэдээллийг дутуу мэдээлсэн	1	919.9			1	919.9		
Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтын дүнг тулган баталгаажуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй	1	4.7					1	4.7
Дүн	2	924.6			1	919.9	1	4.7
Нийт дүн	5	925.6	1	1.0	1	919.9	3	4,7